

Гадаадын зарим улс орны сурах бичигт тавих шаардлагыг харьцуулан судалсан дүн

С.Цогбадрах*

*Боловсролын хүрээлэн, Сурах бичиг, сургалтын орчны судалгааны сектор)***Хураангуй**

Сурах бичгийн чанар түүнийг боловсруулахад баримтлах шаардлага хэрхэн хэмжигдэхүйц байгаатай нягт холбоотой юм. Сурах бичигт тавих шаардлагыг хэмжигдэхүйц болгохын тулд түүний шалгуур, үзүүлэлтийг боловсруулдаг. Зарим улс орнуудын сурах бичигт тавих шаардлагыг бүтцийн түвшин, төсөөтэй ба ялгаатай байдал, хэвлэмэл сурах бичгийн агуулга, арга зүй, хэл найруулга, дизайн, үнэлгээний шаардлагатай нийцэж байгааг илрүүлэхийг зорилоо. Судалгаанд харьцуулалт, задлан шинжлэх, тайлбарлах аргыг ашигласан. ЮНЕСКО, Аль ч улс орны сурах бичгийн агуулгад шинжилгээ хийх арга, Канадын Онтарио муж, Америкийн нэгдсэн улсын эрдэмтдийн судалгаа, АНУ (биологийн сурах бичгийн жишээн дээр), Ахлах сургуулийн биологийн сурах бичгийн үнэлгээ, Англи, Азербайджан, Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага тус бүрийг авч үзсэн. Энэхүү судалгааны үр дүнд бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлагыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байгааг тогтоосон.

Түлхүүр үг

Шаардлага, шалгуур, үзүүлэлт

Удиртгал

Шаардлага нь үйл, ажлыг гүйцэтгэх, бүтээхэд зайлшгүй холбогдох нөхцөл бололцоог нээх илрүүлэхүй юм.

Хэмжинэ гэдэг нь судлагдаж буй үзэгдэл, үйлийн шинжийг тоон болон чанарын хувьд бодитой тодорхойлно гэсэн үг. Хэмжилт хийхийн тулд шалгуур, үзүүлэлтийг боловсруулах шаардлагатай.

Шалгуур нь боловсролын тухайд мэдлэг, чадвар, хандлага, зан үйл, сурах арга барилтай болох зэрэг сургалтын үйл явц, түүний үзүүлэлтийн цогц юм. Үзүүлэлт нь шалгуур хангалтын байдал, түвшин буюу тоон ба чанарын хэмжүүр юм (Цогбадрах, 2018, х.110).

ЮНЕСКО-оос эрхлэн гаргасан” Сурах бичгийн судалгаа хийх, сайжруулах гарын авлага”(2010)-д дунд сургуулийн сурах бичгийн ашиглалтын чанарыг үнэлэхдээ дараах үндсэн асуудалд анхаарсан. Тухайлбал, даалгавар, туршилт ажил, дадлага ажил гүйцэтгэх цаг хугацааг тооцсон байх; суралцагч мэдээллийг хэрхэн олж авах арга, аргачлалыг боловсруулсан байх; суралцагч мэдээллийг хэрхэн судлах аргыг боловсруулсан байх; гэрийн даалгавар нь мэдлэг бүтээх үйлийг дэмжсэн байх зэрэг шаардлагыг багтаажээ (Нарантуяа, 2011, х.31, 32).

Аль ч улс орны сурах бичгийн агуулгад шинжилгээ хийхэд хэрэглэх шаардлага нь үндэсний сургалтын хөтөлбөрийн агуулга, зорилго, зорилттой нийцсэн байх; шинэ мэдлэг олгоход чиглэсэн эсэх; эзэмшсэн мэдлэг, чадварыг

үнэлэхээр агуулгыг сонгосон эсэх; мэдлэг, чадварыг бататгах агуулга тусгасан байх; агуулгыг мэдлэгийн бусад шинжлэх ухааны агуулгатай интеграцчилсан эсэх; шинжлэх ухааны агуулгын түвшинг нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байх; дараалал хөнгөнөөс хүндэд хэрхэн шилжиж байгаа; сэдвүүд бүлэгт жигд хуваарилагдсан байдал; нийгэм, соёлын үнэт зүйлсийг хэр бодитой тусгаж чадсан; лавлагааны аппарат хэр чанартай хийгдсэн; сурган хүмүүжүүлэх лавлах аппарат зэрэг шалгууруудыг багтаажээ (Туяа, 2005, х.44).

Канадын Онтарио мужийн Боловсролын яамнаас 2006 онд ”Сурах бичгийг батлах зөвлөмж”-ийг гаргасан байна. Зөвлөмжид сурах бичгийн формат, дизайн ба агуулгад тавих чанарын шаардлагыг тодорхойлжээ. Тухайлбал: Эх бичвэр болон мэдээлэл нь салаа утгагүй, нас сэтгэхүйн онцлогт тохирсон; агуулгын гүнзгийрэл тохиромжтой, суралцагчдын өмнөх мэдлэг, чадварт тулгуурласан; агуулгыг ойлгомжтой болгохын тулд зураг, дүрслэлийн олон аргыг ашигласан байх зэрэг шаардлагуудыг баримталдаг.

Агуулга нь арьс өнгө, ёс заншил, шашин шүтлэг, нас хүйс, мэдлэг, мэргэжил, нийгэм эдийн, засгийн байдал, улс төр, бэлгийн чиг хандлага, гишүүнчлэл зэргээр ялгаварлахгүй байх шаардлагуудыг оруулсан.

Арга зүй нь сурах арга барилыг дэмжсэн байх; хөтөлбөрт тохирсон мэдлэг, чадварыг эзэмшүүлэх; асуудал шийдвэрлэх арга барилыг эзэмшүүлэх; танин мэдэхүйн түвшин бүрийн дасгал,

* ✉ tsogoo.1207@yahoo.com

даалгаврууд зэрэг шаардлагууд баримталдаг.

Сурах бичгийн арга технологи нь тухайн ангийн агуулгын түвшинд нийцсэн; суралцагчдыг технологи ашиглах чадвараа хөгжүүлэх болон эрүүл мэнд ба аюулгүй байдлыг тооцсон байх; анхааруулга, санамжид аюулгүй ажиллах заавар, дүрмийг боловсруулсан байх шаардлагуудыг багтаасан.

Сурах бичгийн орчны хувьд сургалтын кабинет, тоног төхөөрөмж, үзүүлэн нь агуулгад нийцсэн байх; хэлний түвшин тухайн ангийн суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байх; эх бичвэр болон бичвэр бус мэдээлэл, нэр томъёо, ойлгомжтой байх шаардлагууд багтажээ.6Сурах бичгийн бат бөх, эдэлгээт байдал: Сурах бичгийг чанартай материалаар хийсэн эсэх, сурах бичгийн хэмжээ, жин, хэлбэр суралцагчдын нас, биед тохирсон байх шаардлагууд агуулсан (Боловсролын хүрээлэн, 2014, х.33-39).

Америкийн нэгдсэн улсын эрдэмтдийн судалгаагаар: Сурах бичгийн агуулга нь олон салаа утгагүй байх, арьс өнгө, ёс заншил, шашин шүтлэг, нас хүйс, мэдлэг, мэргэжил, нийгэм, эдийн засгийн байдал, улс төр, бэлгийн чиг хандлага, гишүүнчлэл зэргээр ялгаварлахгүй байх шаардлагуудыг багтаажээ.

Бичвэр нь суралцагчдын унших чадварт тохирсон байх, оновчтой, ойлгомжтой, найруулгын алдаагүй байх.

Агуулга нь суралцагчдын сонирхол, анхаарлыг татахуйц байх, эрэмбэ дараалалтай бичигдсэн; бусдын туршлагыг тусгаж, энгийн хэллэгээр бичигдсэн эсэх; хүүрнэмж, зураг дүрслэл, нэмэлт агуулгатай эсэх; ашигласан материалын эх сурвалжийг тэмдэглэсэн эсэх гэх мэт шаардлагаар тодорхойлогджээ.

Сурах бичгийн арга зүйд тавих шаардлага: Сурах арга барил эзэмшүүлэхэд суралцагчдыг идэвхтэй оролцуулсан байдал; задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг сэтгэхүйн үйлийг эзэмшүүлэхүйц дасгал, даалгавруудыг багтаасан эсэх; суралцагчдын ялгаатай байдлыг дэмжиж буй байдал, дасгал, даалгаврууд нь сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилгод нийцсэн эсэх; ярилцах, хэлэлцүүлэг хийх боломжтой эсэх; асуулт, дасгал, даалгаврууд нь энгийнээс нарийн руу, хүндээс хөнгөн рүү шилжсэн эрэмбэ дарааллаар боловсруулсан эсэх; бүлэг сэдвийн төгсгөлд суралцагчдын эзэмшсэн, хийж сурсан мэдлэг, чадварыг бататгах дасгал, даалгавартай эсэх гэсэн байна (Боловсролын хүрээлэн, 2014, х.40, 41).

Тухайлбал, АНУ-ын ахлах сургуулийн

биологийн сурах бичигт тавих шаардлага нь:

- Сурах бичгийн агуулга нь хичээлийн зорилгод нийцсэн эсэх; хэлэлцэх, ярилцах, дүн шинжилгээ хийх боломжтой эсэх; бичвэр болон бичвэр бус мэдээлэл нь хичээлийн зорилгод нийцсэн байх;
- Бичвэр болон бичвэр бус мэдээлэл бүхий дасгал даалгавар тус бүрийн зорилго суралцагчдад тодорхой, ойлгомжтой байх;
- Суралцагчдын санал бодлыг харгалзан үзэх: бичвэр болон бичвэр бус мэдээлэл, дасгал, даалгавар бүр нь суралцагчдад таамаглах, тайлбарлах, эргэцүүлэн бодох, санал бодлыг гаргахад чиглэсэн боломжтой байх;
- Юмс, үзэгдлийн нийтлэг болон ялгаатай шинж чанарын талаар санаа гаргуулах(гаргасан санааг шинжлэх ухааны хувьд үнэн гэдгийг нотлох)
- Юмс, үзэгдлийг холбоо, хамааралтай үзэл баримтлал, онол, зарчмын үүднээс тайлбарлах, дадлага, туршилт ажил хийх арга барил эзэмшүүлэхүйц байх;
- Шинжлэх ухаанч санааг хөгжүүлж, ашиглаж буй байдал: (Юмс үзэгдлийн холбоо хамаарал, учир шалтгаан, зүй тогтлыг тайлбарлах, хэрэглээний ач холбогдлыг таньж мэдэх, бичвэр болон бичвэр бус мэдээлэл, дасгал даалгавар тус бүрийн хэрэглээг харуулсан байх;)
- Үзэгдэл, үйл явдал, мэдлэгийн талаар эргэцүүлэн бодоход суралцагчдыг дэмжиж буй байдал: (Асуудлыг томъёолж буй байдал, суралцагчдын өөрийн санаа болон шинжлэх ухааны санааг хооронд нь холбоход туслах, түгээмэл илэрдэг буруу төсөөллийг урьдчилан харах, суралцагчдын буруу төсөөлөл болон шинжлэх ухааны үнэн зөв төсөөллийн хоорондын ялгааг гаргах;)
- Суралцагчид юу сурсан талаар бодож тунгаахад тусалж буй байдал: бичвэр болон бичвэр бус мэдээлэл, дасгал, даалгавар бүр нь суралцагчдад өөрсдийн санаа бодол хэрхэн өөрчлөгдсөнийг хянахад чиглэгдсэн байх;
- Сурлагын ахиц дэвшлийг үнэлэх; сонирхолтой асуулт тавихыг дэмжих; бүх суралцагчдыг дэмжих (бичвэр болон бичвэр бус мэдээлэл, дасгал, даалгавар бүр нь бүх суралцагчид идэвхтэй оролцох, амжилт гаргах боломжийг хангасан эсэх) зэрэг болно (Боловсролын хүрээлэн, 2014, х.8-10).
- Сурах бичиг нь суралцагчдын хувьд

сонирхолтой байхын тулд хэд хэдэн шаардлагыг хангасан байх нөхцөлүүдийг тодорхойлжээ.

- Суралцагчдын эзэмшвэл зохих мэдлэг, оюун ухааны чадвар нь зайлшгүй хэрэгтэй гэдэгт итгүүлэхийн тулд түүнийг сонирхолтой байдлаар тайлбарлах
- Суралцагчдын оюун ухааны бүтээлч чадварыг урамшуулах нөхцөлийг бүрдүүлэх. Мэдлэгийг суралцагчдад бэлнээр өгөх бус тэд өөрсдөө мэдлэгээ олж авахад суралцагчдаар өөрсдөөр нь бие даалган хариултыг олуулахад чиглэсэн байх
- Хийсвэр дүрмийн ойлголтыг зургаар илэрхийлэх, дүржүүлсэн сургалтын материал нь илүү үр дүнтэй.
- Төрөл бүрийн сургалтын материалыг ашиглах шаардлагатай.
- Материал нь 11-12 настай хүүхдийн түвшинд нийцсэн, хөнгөн хялбар байх (Граник, Бондаренко, 1970, х.71)

Сурах бичигт тавих шаардлага: Ажлын хуудас зорилгод нийцсэн байх; нэгж сэдэв, бүлгийн агуулга нь хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангаж буй байдал; суралцагчдын нас, сэтгэлзүйн онцлогт тохирсон, агуулгын хувьд хэл найруулга алдаагүй, ойлгомжтой байх; монгол орны нийгэм, эдийн засаг, улс орны тулгамдсан асуудлыг хөндсөн зураг, жишээ байгаа эсэх; асуулт, даалгаврууд нь суралцахуйн болон сэтгэн бодох чадварыг идэвхтэй дэмжихүйц байдлаар боловсруулсан байх; асуулт, даалгаврууд суралцагчдад юуг хийж сурсан талаар анализ хийх, сураагүй зүйлийг оношлох боломж олгож буй зэрэг шаардлагууд орсон байна (Gillen Lindsen, 2015, х.1, 2).

Азербайджан улсын дунд сургуулийн сурах бичгийн агуулга нь боловсролын стандартад нийцсэн байдал; тоо баримтын үнэн зөв, тодорхой болон бодит байдлыг харуулсан байх; академик ба прагматик харьцааг оновчтой боловсруулсан байх; танин мэдэхүйн түвшинд бичигдсэн байдал; энгийнээс хүнд рүү чиглэсэн эсэх; агуулга залгамж холбоотой байх зэрэг шаардлагуудыг авч үздэг (Нарантуяа, 2011, х.53).

Агуулга хичээлийн зорилгод тохирсон байх; дасгал, даалгавар нь хичээлийн зорилгод нийцсэн байх; дасгал, даалгавар нь логик дараалалтай боловсруулсан байх; өмнөх, мэдлэг чадварыг залгамж холбоо; агуулга нь

нийтлэг санаа руу суралцагчдыг хөтөлсөн байх; сурагчдын санал бодлыг танин мэдэхэд багшийн оролцоо; агуулга нь юмс үзэгдлийг олон талаас тайлбарлахаар боловсруулсан байх; даалгавар нь туршилт, дадлага ажлын үр дүнд гүйцэтгэхээр боловсруулсан даалгавартай байх; шинжлэх ухааны санааг учир утгатайгаар өгөх; гол санааг үнэн зөв, ойлгомжтой гаргасан байх; агуулга нь хэрэглээний мэдлэг эзэмшүүлэхэд чиглэсэн байх; даалгавар нь практик чадварыг үнэлэхэд чиглэсэн байх; суралцагчдын санаагаа тайлбарлахыг дэмжсэн байх; тайлал, эргэцүүллийг хийхэд чиглэсэн байх; сурсан зүйлийнхээ талаар бодож, тунгаахад чиглэсэн байх; үнэлж болохуйц агуулгыг сонгосон байх; танин мэдэхүйн түвшинд даалгавар боловсруулсан байх; явцын болон эцсийн үнэлгээний даалгавартай байх; багшид зориулсан нэмэлт агуулга байх; асуулт тавихыг дэмжсэн байх; бүх сурагчдын оролцоог дэмжсэн байх шаардлагуудыг баримталдаг. (Боловсролын хүрээлэн, 2014, х.22-36).

Арга зүй

Зарим улс орнуудын сурах бичигт тавих шаардлагыг бүтцийн түвшинд, хэвлэмэл сурах бичгийн агуулга, арга зүй, хэл найруулга, дизайн, үнэлгээний шаардлагатай хэрхэн нийцэж байгааг, шаардлагын ижил ба төстэй ялгааг илрүүлэхийг зорилоо.

Судалгааны арга

1. Харьцуулалтын арга
2. Задлан шинжлэх арга
3. Тайлбарлах арга

Хамрах хүрээ

Юнеско, Аль ч улс орны сурах бичгийн агуулгад шинжилгээ хийхэд хэрэглэх шаардлага, Канадын Онтарио муж, Америкийн нэгдсэн улсын эрдэмтдийн судалгаа, АНУ (биологийн сурах бичгийн жишээн дээр), Ахлах сургуулийн биологийн сурах бичгийг үнэлэхэд ашиглах шаардлага, Кимбриж, Азербайджан, Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага

Үр дүн

Хүснэгт 1

Зарим улс орнуудын сурах бичигт тавих шаардлагыг бүтцийн түвшинд харьцуулсан судалгааны дүн

	Сурах бичигт тавих шаардлагын бүтэц	Нийт шаардлагын тоо	Агуулгын шаардлагын эзлэх хувь	Арга зүйн шаардлагын эзлэх хувь	Найруулгын шаардлагын эзлэх хувь	Дизайны шаардлагын эзлэх хувь	Үнэлгээний шаардлагын эзлэх хувь
	Улсын нэр						
1	ЮНЕСКО	4	-	100%	-	-	
2	Аль ч улс орны сурах бичгийн агуулгад шинжилгээ хийхэд хэрэглэх шаардлага	10	100%	-	-	-	
3	Канадын Онтарио муж	16	47%	41%	-	12%	
4	Америкийн нэгдсэн улсын эрдэмтдийн судалгаагаар	13	46.6%	46.6%	6.8%	-	
5	АНУ (биологийн сурах бичгийн жишээн дээр)	12	50%	50%	-	-	
6	Ахлах сургуулийн биологийн сурах бичгийг үнэлэхэд ашиглах шаардлага	21	47.6%	38.2 %	-	-	14.2%
7	Англи	6	16.7%	66.6%	16.7%	-	-
8	Азербайджан	7	100%	-	-	-	-
9	Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага	34	26.4%	23.5%	14.7%	17.6%	17.8%

Хүснэгт 1- ээс үзэхэд судалгаанд хамрагдсан зарим улс орны 44.4 хувь нь 4-10 хүртэл, 33.3 хувь нь 12-13 хүртэл, 22.2 хувь нь 16-34 хүртэл тооны шаардлагыг сурах бичиг зохиоход хэрэглэдэг байна.

Хүснэгт 2

Зарим улс орнуудын сурах бичигт тавих шаардлагыг хэвлэмэл сурах бичгийн агуулга, арга зүй, хэл найруулга, дизайн, үнэлгээний шаардлагатай харьцуулсан судалгааны дүн

	Хэвлэмэл сурах бичигт тавих шаардлагын бүтэц	Нийт шаардлагын тоо	Агуулгын шаардлагад тохирч буй хувь	Арга зүйн шаардлагад тохирч буй хувь	Найруулгын шаардлагад тохирч буй хувь	Дизайны шаардлагад тохирч буй хувь	Үнэлгээний шаардлагад тохирч буй хувь
	Улсын нэр						
1	Юнеско	4	-	-	-	-	25%
2	Аль ч улс орны сурах бичгийн агуулгад шинжилгээ хийхэд хэрэглэх шаардлага	10	70%	-	-	10%	-
3	Канадын Онтарио муж	16	87.5%	-	6.2%	-	-
4	Америкийн нэгдсэн улс	13	35.7%	21.4%	14.2%	-	-
5	АНУ (биологийн сурах бичгийн жишээн дээр)	12	-	-	-	-	-
6	Ахлах сургуулийн биологийн сурах бичгийг үнэлэхэд ашиглах шаардлага	21	9.5%	23.8%	-	-	9.5%
7	Англи	6	33.3%	16.6%	16.6%	-	-
8	Азербайджан	6	100%		-	-	-
	Нийт	88					

Хүснэгт 2-ээс үзэхэд Азербайджан, Канадын Онтарио муж, Аль ч улс орны сурах бичгийн агуулгад шинжилгээ хийхэд хэрэглэх шаардлагууд 70-100 хувьтай бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичгийн агуулгад тавих шаардлагатай тохирч байна.

Хүснэгт 3

Зарим улс орнуудын болон бага дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлагын ижил болон ялгаатай талыг харьцуулан судалсан дүн

	Ижил, төсөөтэй шаардлага		Ялгаатай шаардлага
1	Гэрийн даалгавар нь мэдлэг бүтээх үйлийг дэмжсэн байх	1	Даалгавар, туршилт ажил, дадлага ажил гүйцэтгэх цаг хугацааг тооцсон байх;
2	Үндэсний сургалтын хөгөлбөрийн агуулга, зорилго, зорилттой нийцсэн байх;	2	Суралцагч мэдээллийг хэрхэн олж авах арга, аргачлалыг боловсруулсан байх;
3	Шинэ мэдлэг олгоход чиглэсэн эсэх	3	Суралцагч мэдээллийг хэрхэн судлах аргыг боловсруулсан байх;
4	Эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэхээр агуулгыг сонгосон эсэх;	4	Лавлагааны аппарат хэр чанартай хийгдсэн
5	Дараалал хөнгөнөөс хүндэд хэрхэн шилжиж байгаа;	5	Сурган хүмүүжүүлэх лавлах аппарат хэр
6	Агуулгыг мэдлэгийн бусад шинжлэх ухааны агуулгатай интеграцчилсан эсэх;	6	Агуулгыг ойлгомжтой болгохын тулд зураг, дүрслэлийн олон аргыг ашигласан байх
7	Шинжлэх ухааны агуулгын түвшинг нас сэтгэхүйн онцлогт тохирсон байх;	7	Агуулга нь арьс өнгө, ёс заншил, шашин шүтлэг, нас хүйс, мэдлэг, мэргэжил, нийгэм эдийн, засгийн байдал, улс төр, бэлгийн чиг хандлага, гишүүнчлэл зэргээр ялгаварлахгүй байх
8	Мэдлэг, чадварыг бататгах агуулга тусгасан байх;	8	Суралцагчдыг технологи ашиглах чадвараа хөгжүүлэх
9	Нийгэм, соёлын үнэт зүйлсийг хэр бодитой тусгаж чадсан;	9	Арьс өнгө, ёс заншил, шашин шүтлэг, нас хүйс, мэдлэг, мэргэжил, нийгэм, эдийн засгийн байдал, улс төр, бэлгийн чиг хандлага, гишүүнчлэл зэргээр ялгаварлахгүй байх
10	Сэдвүүд бүлэгт жигд хуваарилагдсан байдал;	10	Ашигласан материалын эх сурвалжийг тэмдэглэсэн эсэх
11	Сурах арга барилыг дэмжсэн байх;	11	Сурах арга барил эзэмшүүлэхэд суралцагчдыг идэвхтэй оролцуулсан байдал;
12	Мэдлэг, чадварыг эзэмшүүлэх агуулгыг сонгох	12	Ярилцах, хэлэлцүүлэг хийх боломжтой эсэх;
13	Асуудал шийдвэрлэх арга барилыг эзэмшүүлэх	13	Сурах бичгийн агуулга нь хичээлийн зорилгод нийцсэн эсэх
14	Танин мэдэхүйн түвшин бүрийн дасгал, даалгавруудыг багтаасан байх	14	Хэлэлцэх, ярилцах, дүн шинжилгээ хийх боломжтой эсэх;
15	Эрүүл мэнд ба аюулгүй байдлыг тусгасан анхааруулга, санамжид аюулгүй ажиллах заавар, дүрмийг боловсруулсан байх	15	Бичвэр болон бичвэр бус мэдээллийн агуулга нь хичээлийн зорилгод нийцсэн байх
16	Сурах бичгийн орчны хувьд сургалтын кабинет, тоног төхөөрөмж, үзүүлэн нь агуулгад нийцсэн байх;	16	Суралцагчдын санал бодлыг харгалзан үзэх: бичвэр болон бичвэр бус мэдээлэл, дасгал, даалгавар бүр нь суралцагчдад таамаглах, тайлбарлах, эргэцүүлэн бодох, санал бодлыг гаргахад чиглэгдсэн боломжтой байх;-
17	Хэлний түвшин тухайн ангийн суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байх;	17	Сурах бичиг нь суралцагчдын хувьд сонирхолтой байх
18	Эх бичвэр болон бичвэр бус мэдээлэл, нэр томьёо, ойлгомжтой байх	18	Юмс, үзэгдлийн нийтлэг болон ялгаатай шинж чанарын талаар санаа гаргуулах(гаргасан санааг шинжлэх ухааны хувьд үнэн гэдгийг нотлох)-
19	Сурах бичгийн бат бөх, эдэлгээт байдал: Сурах бичгийг чанартай материалаар хийсэн эсэх, сурах бичгийн хэмжээ, жин, хэлбэр суралцагчдын нас, биед тохирсон байх	19	Юмс, үзэгдлийг холбоо, хамааралтай үзэл баримтлал, онол, зарчмын үүднээс тайлбарлах, дадлага, туршилт ажил хийх арга барил эзэмшүүлэхүйц байх;
20	Агуулга нь олон салаа утгагүй байх;	20	Шинжлэх ухаанч санааг хөгжүүлж, ашиглаж буй байдал: Юмс үзэгдлийн холбоо хамаарал, учир шалтгаан, зүй тогтлыг тайлбарлах, хэрэглээний ач холбогдлыг таньж мэдэх, бичвэр болон бичвэр бус мэдээлэл, дасгал даалгавар тус бүрийн хэрэглээг харуулсан байх
21	Бичвэр нь суралцагчдын унших чадварт тохирсон байх, оновчтой, ойлгомжтой, найруулгын алдаагүй байх.	21	Үзэгдэл, үйл явдал, мэдлэгийн талаар эргэцүүлэн бодоход суралцагчдыг дэмжиж буй байдал: Асуудлыг томъёолж буй байдал, суралцагчдын өөрийн санаа болон шинжлэх ухааны санааг хооронд нь холбоход туслах, түгээмэл илэрдэг буруу төсөөллийг урьдчилан харах, суралцагчдын буруу төсөөлөл болон шинжлэх ухааны үнэн зөв төсөөллийн хоорондын ялгааг гаргах

22	Агуулга нь суралцагчдын сонирхол, анхаарлыг татахуйц байх, эрэмбэ дараалалтай бичигдсэн байх	22	Суралцагчид юу сурсан талаар бодож тунгаахад тусалж буй байдал: бичвэр болон бичвэр бус мэдээлэл, дасгал, даалгавар бүр нь суралцагчдад өөрсдийн санаа бодол хэрхэн өөрчлөгдсөнийг хянахад чиглэгдсэн байх;-
23	Бусдын туршлагыг тусгаж, энгийн хэллэгээр бичигдсэн эсэх;	23	Сурлагын ахиц дэвшлийг үнэлэх; сонирхолтой асуулт тавихыг дэмжих; бүх суралцагчдыг дэмжих (бичвэр болон бичвэр бус мэдээлэл, дасгал, даалгавар бүр нь бүх суралцагчид идэвхтэй оролцох, амжилт гаргах боломжийг хангасан байх
24	Хүүрнэмж, зураг дүрслэл, нэмэлт агуулгатай эсэх;	24	Ажлын хуудас зорилтод нийцсэн байх;
25	Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг сэтгэхүйн үйлийг эзэмшүүлэхүйц дасгал, даалгавруудыг багтаасан эсэх;	25	Асуулт, даалгаврууд суралцагчдад юуг хийж сурсан талаар анализ хийх, сураагүй зүйлийг оношлох боломж олгож буй
26	Суралцагчдын ялгаатай байдлыг дэмжиж буй байдал, дасгал, даалгаврууд нь сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцсэн эсэх;	26	Агуулга нь боловсролын стандартад нийцсэн байдал;
27	Асуулт, дасгал, даалгаврууд нь энгийнээс нарийн руу, хүндээс хөнгөн рүү шилжсэн эрэмбэ дарааллаар боловсруулсан эсэх;	27	Академик ба прагматик харьцааг оновчтой боловсруулсан байх;
28	Бүлэг сэдвийн төгсгөлд суралцагчдын эзэмшсэн, хийж сурсан мэдлэг, чадварыг бататгах дасгал, даалгавартай эсэх	28	Агуулга хичээлийн зорилгод тохирсон байх;
29	Бичвэр болон бичвэр бус мэдээлэл бүхий дасгал даалгавар тус бүрийн зорилго суралцагчдад тодорхой, ойлгомжтой байх	29	Даалгавар нь хичээлийн зорилгод нийцсэн байх;
30	Нэгж сэдэв, бүлгийн агуулга нь хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангаж буй байдал;	30	Дасгал, даалгавар нь логик дараалалтай боловсруулсан байх;
31	Агуулгын хувьд хэл найруулга алдаагүй, ойлгомжтой байх	31	Агуулга нь нийтлэг санаа руу суралцагчдыг хөтөлсөн байх;
32	Монгол орны нийгэм, эдийн засаг, улс орны тулгамдсан асуудлыг хөндсөн зураг, жишээ байгаа эсэх	32	Сурагчдын санал бодлыг танин мэдэхэд багшийн оролцоо;
33	Асуулт, даалгаврууд нь суралцахуйн болон сэтгэн бодох чадварыг идэвхтэй дэмжихүйц байдлаар боловсруулсан байх;	33	Агуулга нь юмс үзэгдлийг олон талаас тайлбарлахаар боловсруулсан байх;
34	Тоо баримт үнэн зөв, тодорхой болон бодит байдлыг харуулсан байх;	34	Даалгавар нь туршилт, дадлага ажлын үр дүнд гүйцэтгэхээр боловсруулсан даалгавартай байх ;
35	Агуулга танин мэдэхүйн түвшинд бичигдсэн байдал	35	Шинжлэх ухааны санааг учир утгатайгаар өгөх;
36	Агуулга энгийнээс хүнд рүү чиглэсэн эсэх;	36	Гол санааг үнэн зөв, ойлгомжтой гаргасан байх;
37	Агуулга залгамж холбоотой байх	37	Агуулга нь хэрэглээний мэдлэг эзэмшүүлэхэд чиглэсэн байх;
38	Дасгал, даалгавар нь логик дараалалтай боловсруулсан байх;	38	Суралцагчдын санаагаа тайлбарлахыг дэмжсэн байх;
39	Өмнөх, мэдлэг чадварын залгамж холбоо;	39	Тайлал, эргэцүүллийг хийхэд чиглэсэн байх;
40	Даалгавар нь практик чадварыг үнэлэхэд чиглэсэн байх;	40	Сурсан зүйлийнхээ талаар бодож, тунгаахад чиглэсэн байх;
41	Үнэлж болохуйц агуулгыг сонгосон байх;	41	Асуулт тавихыг дэмжсэн байх;
42	Танин мэдэхүйн түвшинд даалгавар боловсруулсан байх;	42	Бүх сурагчдын оролцоог дэмжсэн байх
43	Явцын болон эцсийн үнэлгээний даалгавартай байх;	43	Бичвэр болон бичвэр бус мэдээлэл бүхий дасгал даалгавар тус бүрийн зорилго суралцагчдад тодорхой, ойлгомжтой байх;
44	Багшид зориулсан нэмэлт агуулга байх;	44	Асуулт, даалгаврууд суралцагчдад юуг хийж сурсан талаар анализ хийх, сураагүй зүйлийг оношлох боломж олгож буй байдал

Дээрх судалгааны үр дүнгээс үзэхэд нийт 88 шаардлагаас 44 нь ижил төстэй, 44 нь ялгаатай байгааг тогтоосон. Ижил төстэй 44 шаардлагаас 44 хувь нь агуулга, 50 хувь нь арга зүй, 4 хувь нь хэл найруулга, 2 хувь нь дизайнд буюу Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлагад нийцэж байна.

Дүгнэлт

1. Судалгааны дүнгээс үзэхэд 77.7 хувь нь агуулга, арга зүй, хэл найруулга, дизайнд тавих шаардлагыг бүрэн агуулсан, нарийн бүтэцчилээгүй 4-16 хүртэлх шаардлагыг багтаасан цогц хэлбэрээр боловсруулсан байна. Бага дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага (MNS5418:2008 монгол улсын стандарт) нь агуулгад 9, арга зүйд 8, үнэлгээд 6, хэл найруулгад 5, дизайнд 6 нийт 34 шаардлагыг тус тус багтаасан байна. Үүнээс үзвэл бага дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага нь нарийн бүтэцтэй, олон шаардлагатай байгааг боловсролын бодлого, хөтөлбөрийн шинэчлэл өөрчлөлтөд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатайгаас гадна судлагдахуун тус бүрийн онцлогт тохирсон шаардлага, түүний шалгуур, үзүүлэлтийг боловсруулах хэрэгцээ буй болжээ.
2. Бага дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага нь сурах бичиг бүтээгчдээс уг сурах бичгийн эхийг бэлтгэж дуусах үед хийх зохиогчийн эхийн чанарыг, зохиогчийн эхийг хэвлэлд шилжүүлж, хэвлэлийн бэлтгэгдсэн эхийн чанарыг, хэвлэгдээд гарсан сурах бичгийн чанарт үнэлгээ хийхэд учир дутагдалтай байна. Иймд сурах бичиг бүтээгчдээс уг сурах бичгийн эхийг бэлтгэж

дуусах үед хийх зохиогчийн эхийн чанарыг, зохиогчийн эхийг хэвлэлд шилжүүлж, хэвлэлийн бэлтгэгдсэн эхийн чанарыг, хэвлэгдээд гарсан сурах бичгийн чанарт үнэлгээ хийх шаардлага, түүний шалгуур, үзүүлэлтийг боловсруулах хэрэгцээ байгаа гэж дүгнэж байна.

Ашигласан материал

- Gillen Lindsen, (2015). Mongolia-Cambridge Education. page.1 of 2. Улаанбаатар
- Граник, Г.Г., Бондаренко, С.М. (1970). Сурах бичгийг туршин шалгасан туршлага. Эрдэм шинжилгээний өгүүлэл. 71.
- Нарантуяа, Ж. (2011). Дунд сургуулийн сурах бичгийн чанарын үнэлгээний асуудалд. Боловсрол судлал сэтгүүл, дугаар 77, 52-53.
- Туяа, Л. (2005). Гадаад хэлний сурах бичгийн шинжилгээний арга зүйн зарим асуудал. 66. Улаанбаатар
- Цогбадрах, С. (2018). Сурах бичгийн агуулга, арга зүйд тавих шаардлагыг боловсронгуй болгох нь (Биологийн сурах бичгийн жишээн дээр). Боловсрол судлалын докторын (Ph.D) зэрэг горилсон диссертаци, 109. Улаанбаатар
- Боловсролын хүрээлэн. (2014). Гадаад улс орны сурах бичиг бэлтгэх, бодлого, чанарын үнэлгээний арга туршлага тайлан. 8-10, 38, 39, 40-41. Улаанбаатар
- Боловсролын хүрээлэн. (2014). Шинжлэх ухааны дэвшлийн Америкийн нийгэмлэг ахлах сургуулийн биологийн сурах бичгийн жишигт суурилсан үнэлгээ төслийн тайлан 2061. 22-36. Улаанбаатар

Comparative study of the requirements for textbooks in some foreign countries

S.Tsogbadrakh

Mongolian institute for educational research

Abstract

A quality of textbooks development largely depends on the requirements which are measurable to some extent. In order to make textbook requirements measurable, certain criteria are usually developed. In our study, we tried to compare a structure of requirements, similarities and differences, content, methodology, writing style, and design of the printed textbooks in some countries. Some research instruments such as comparison, analysis and explanation have been used in this study. Experiences of international scholars from UNESCO, Canadian Ontario state, USA (based on the biology textbook studies), as well as high school biology textbook evaluation, UK and Azerbaijan requirements for primary and secondary school printed textbooks have been examined and analyzed. As a result of the study, we have come to the conclusion that there is a need to elaborate and improve the requirements for primary and secondary school textbooks.

Key words

Requirement, criterion, indicator